



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

ХИИ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын ХИИ хурал 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагаас Төрийн ордны "Б" танхимд 96 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр дуустал сунгах тухай Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал;

2. Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг сунгах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг;

3. Олон улсын хуваарьт нислэг, төмөр замын олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг сунгах тухай Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаа, олон улсын хуваарьт нислэг, төмөр замын олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг сунгахтай холбогдуулан хилийн боомтуудын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн;

5. Коронавируст халдварын нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл нарын мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

А. 1. Коронавируст халдварын нөхцөл байдал, Улсын онцгой комиссын гишүүдийн саналыг үндэслэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл;

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгахтай холбогдуулан бүх шатны боловсролын байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг түр зогсоосон хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл;

3. Олон улсын хуваарьт нислэг, төмөр замын олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл тус тус сунгаж, холбогдох бусад арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэв.

Б. Энэ шийдвэртэй холбогдуулан Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхээр тогтов.

Нэг. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадралд;

1.1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн танилцуулах;

Хоёр. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг,

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан нарт;

2.1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгахтай холбогдуулан бүх шатны боловсролын байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааг зогсоосон хугацаа, олон улсын хуваарьт нислэг, төмөр замын олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоосон хугацааг сунгах, авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын холбогдох арга хэмжээний талаар Засгийн газрын тогтоолын төсөлд оруулах санал боловсруулж танилцуулах;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт;

3.1. Эхний ээлжинд Монгол Улс, Япон Улс хооронд захиалгат нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах;

3.2. Засгийн газар хоорондын томоохон бүтээн байгуулалтын төсөл дээр ажиллах гадаадын ажиллах хүчнийг Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар чиглэлийн захиалгат нислэгээр авчрах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.3. Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар чиглэлээр захиалгат нислэг үйлдэхтэй холбогдуулан БНХАУ-руу зорчих гадаадын иргэн болон тухайн улсад байнга оршин суудаг, ажиллаж, суралцдаг, хүндэтгэн үзэх шалтгаантай Монгол Улсын иргэдийн бүртгэлийг хийж зохион байгуулах;

Дөрөв. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

4.1. Халдвартай, сэжигтэй, ажиглалтанд байгаа иргэдэд эмчилгээ сувилгаа хийж буй эмч, эмнэлгийн ажилтан, голомттой бүс нутгаас иргэдийг тээвэрлэн авчирсан болон нэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд онцгой анхаарал тавих, дэглэм журмыг чанд мөрдөж ажиллах;

4.2. Тусгаарлах байрнаас гарсан иргэдийн тоо бүртгэлийг тухай бүр танилцуулах;

Тав. Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав нарт:

5.1. “Алтанбулаг” хилийн боомтоос хилийн гаалийн хяналтад явж буй транзит болон улс хоорондын гадны орны ачаа тээврийн хэрэгсэлд бүрэн халдваргүйжүүлэлт хийж, нэгдсэн зохион байгуулалттайгаар цагдаагийн хамгаалалт, хяналтын дор төв, суурин газруудад зогсохгүйгээр “Замын-Үүд” хилийн боомт хүртэл шуурхай хөдөлгөөн үйлдэх арга хэмжээ авч ажиллах;

Зургаа. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт:

6.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгахтай холбогдуулан хилийн боомтоор зорчигч хөдөлгөөнийг зохицуулах (гадаад улс орноос ирэх иргэдийг зөвхөн “Буянт-Ухаа”, “Алтанбулаг”, “Замын-Үүд” хилийн боомтоор хүлээн авах гэх мэт), холбогдох арга хэмжээ авах саналыг боловсруулан Засгийн газрын тогтоолын төсөлд тусган шийдвэрлүүлэх;

Долоо. Засгийн газрын гишүүд,
агентлагийн дарга,
аймаг нийслэлийн Засаг дарга нарт:


7.1. Гадаад улс орноос Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд, Монгол Улсад байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд, Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэд, тэдний дундаас төрсөн хүүхэд, томоохон бүтээн байгуулалтын төсөлд ажиллах гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлмэгц 14 хоног тусгаарлах арга хэмжээ авч ажиллах;

7.2. Тусгаарлах байрнаас гарсан иргэнийг 14 хоногийн хугацаанд, коронавируст халдвараар өвчлөөд эдгэрсэн иргэнийг эмнэлэгээс гарсан өдрөөс хойш 28 хоногийн хугацаанд тухайн иргэний оршин суугаа засаг захиргааны нэгж, баг, хорооны засаг дарга, цагдаагийн хэсэг, сууц өмчлөгчдийн холбоо, сайн дурын ажилтнуудыг дайчлан хянах;

7.3. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэхэд зарцуулсан зардлыг төсвийн багцдаа зохицуулалт хийх замаар шийдвэрлүүлэх саналаа яаралтай боловсруулан танилцуулахыг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  Ө.ЭНХТҮВШИН



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ  Г.АРИУНБУЯН